



**“Шударга ёсны төлөө-2016” уралдааныг улсын хэмжээнд нийт төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын дунд зарлаж байна.**

Шалгуур үзүүлэлт:

**1. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл зориг, эрмэлзэлтэй удирдлага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Олон нийт тэр дундаа төрийн байгууллагын удирдах ажилтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, уриалах, үлгэр дууриалал үзүүлэх

*Шалгуур :*

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлэх аргачлалын Авлигатай тэмцэх санал санаачилгын шалгуур үзүүлэлтээр 25-аас дээш оноогоор үнэлэгдсэн, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шинэлэг ажил, үр дүнтэй арга хэмжээ санаачлан хэрэгжүүлсэн, хөндлөнгийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлсэн шударга, хариуцлагатай байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийн үр дүнг тооцох, ажилтан, албан хаагчиддаа нөлөөлөх чиглэлээр бодитой ажил хэрэгжүүлсэн төрийн, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах ажилтныг энэ номинацид нэр дэвшүүлнэ.

**2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон нийтэд хүртээмжтэй, оролцоог хангасан болон байгууллагын алба хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх аян зохион байгуулсан байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Иргэд, олон нийтийн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, уриалах, үлгэр дууриалал үзүүлэх

*Шалгуур үзүүлэлт:*

- Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө төсөвлөн зарцуулсан, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран дотооддоо аян, арга хэмжээ зохион байгуулсан, аяны уриа, уриалга, мэдэгдэл, амлалтыг олон нийтэд зарласан, сургалт сурталчилгаа явуулсан, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тусгайлан удирдамж төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн, үр дүнд хүрсэн ажлууд хийсэн төрийн, төрийн өмчит хуулийн этгээдийг нэр дэвшүүлнэ.

### **3. Ил тод, нээлттэй цахим хуудастай байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Авлигаас урьдчилан сэргийлэх нэг гол үйл ажиллагаа бол мэдээллийн ил тод байдлыг хангах явдал байдаг. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд мэдээллээ ил тод болгох нэг хэлбэр нь байгууллагын цахим хуудас тул хуулийн хэрэгжилтийг хангах жишиг бий болгох, бусад байгууллагад үлгэр дууриал, туршлага болгох.

*Шалгуур үзүүлэлт:*

- Мэдээллийн ил тод мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хэрэгжилтийг хангах чиглэлээр санаачилгатай ажилласан, мэдээлэл технологийн чиглэлээр тогтсон стандарт хангасан гэж дүгнэгдсэн, мэдээллийн баазыг тогтмол хуулийн хугацаанд шинэчлэн, иргэдэд мэдээллийг ойлгомжтой, энгийн байдлаар хүргэх /хэлбэр, агуулга/, иргэдэд төрийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэхдээ шинэ арга хэлбэрийг ашигласан, мэдээллийг хялбар хурдан олж авах боломжийг бүрдүүлсэн байгууллага, хамт олныг нэр дэвшүүлнэ.

### **4. Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх талаар шинэ санал, санаачилга гаргасан төрийн байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалгарсан үйл ажиллагааг улсын хэмжээнд тэргүүн туршлага болгон нэвтрүүлэх.

*Шалгуур:*

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэл учруулахгүй хүргэх талаар үйл ажиллагааны шинэ санал санаачилга нэвтрүүлсэн, дэвшилтэд техник, технологи нэвтрүүлсэн, удирдлага, дотоод зохион байгуулалтын арга хэмжээ нэвтрүүлсэн нь бодитой үр дүн үзүүлсэн, эдгээр нэвтрүүлсэн үйл ажиллагаанд мониторинг хийж санал дүгнэлт өгсөн, энэ үйл ажиллагаа нь бусад чиг үүргийн хувьд ижил төстэй байгууллагуудад туршлага болгож нэвтрүүлж болох ажлыг зохион байгуулсан байгууллагыг нэр дэвшүүлнэ.

## **5. Идэвхи, санаачилгатай Эрх бүхий албан тушаалтан**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ХАСХОМ-ийн бүртгэх, хянах, хадгалах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, хэвшүүлэх, энэ чиглэлээр бусад эрх бүхий албан тушаалтнуудад үлгэр дууриалал болох.

*Шалгуур:*

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр албан хаагчдаа авлигын эрсдэлээс хамгаалах ажлуудыг бодитой хийсэн /сургалт сурталчилгаа, мэдэгдэл тайлбар гаргах, гарын авлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх, гарын авлага, тараах материал өөрөө санаачлан боловсруулсан, хэвлүүлсэн гэх мэт/, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт болон ХАСХОМ хүлээн авах, бүртгэх, тайлагнах зэрэг тайлан мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд гарган ирүүлсэн, хариуцсан ажилдаа идэвхи, санаачилга, хариуцлагатай ажилладаг, АТГ-аас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог, тухайн хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол шалгагдаж, зөрчил тогтоогдоогүй эрх бүхий албан тушаалтанг энэ номинацид нэр дэвшүүлнэ.

**6. Хүүхэд залууст шударга ёсыг ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллага, ТББ, хэвлэл мэдээллийн байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд хүүхэд залуучуудад авлигын эсрэг үзэл санааг таниулах, ухуулах;

*Шалгуур:*

- Авлигатай тэмцэх газраас хүүхэд залуучуудад зориулан хэвлүүлсэн гарын авлага, судалгааны дүнг ашиглан зорилтот бүлэгт чиглэсэн сурталчлан таниулах, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр өөрөө санал санаачлага гарган ажилласан, сургалтын байгууллага хүүхдэд шударга ёс, зөв зан үйлийг сурталчлах чиглэлээр сургалтын шинэ арга, хэлбэр нэвтрүүлсэн, сургалтын гарын авлага, материал /хэвлэмэл, видео, аудио/ бэлтгэн хүргэсэн, хэвлэл, мэдээллийн байгууллага нийтлэл, нэвтрүүлэг, үйл ажиллагааныхаа бодлогыг чиглүүлэн ажилласан байгууллага, хамт олныг энэ номинацид нэр дэвшүүлнэ.

**7. “Шударга ёс бидний тэмүүлэл” хичээлийн хөтөлбөрийг хүүхэд залууст сонирхолтой хэлбэрээр баяжуулан таниулах ажлыг зохион байгуулсан сургалтын байгууллага /төр, хувийн хэвшлийн ерөнхий боловсролын байгууллага/**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд хүүхэд залуучуудад авлигын эсрэг үзэл санааг таниулах, ухуулах, шударга зан үйлийг төлөвшүүлэх;

*Шалгуур:*

- Шударга ёс бидний тэмүүлэл” хичээлийн хөтөлбөрийн гарын авлагын агуулгыг баяжуулан сурагчдад мэдлэг, мэдээлэл өгөх ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн, хичээл, бусад арга хэлбэрээр сурталчлан таниулах шинэ хөтөлбөр боловсруулан хүргэсэн, үр дүнг тооцсон, сургалт, арга хэмжээнд хамрагдсан сурагчдын болон зохион байгуулсан арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй тайлан ирүүлсэн, хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, хүргэх чиглэлээр багш нарын дунд компанит ажил зохион байгуулсан сургалтын

байгууллага /төрийн болон хувийн ерөнхий боловсролын сургууль хамаарна/ нэр дэвшүүлнэ.

## **8. Салбарын шударга байдлыг дэмжих аянд идэвхитэй оролцсон хамт олон, байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Иргэдэд үзүүлж буй үйлчилгээг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй болгох, авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал гарахаас урьдчилан сэргийлсэн тодорхой үр дүн бүхий ажлыг санаачлан ажилласан бусад салбарын байгууллагуудад хэрэгжүүлж болох сайн санаачилга, тэргүүн туршлага илрүүлэх

Шалгуур:

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ идэвхи санаачилгатай хэрэгжүүлсэн, иргэдэд үзүүлж буй төлбөрт үйлчилгээний жагсаалтыг мэдээллийн самбар болон кассын дэргэд энгийн, ойлгомжтой байдлаар байршуулах, байгууллагын ажилтны бэлэн мөнгөтэй шууд харьцахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх болон үзүүлсэн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй болгосон байх, салбарын болон байгууллагын ёс зүйн дүрмийг сурталчлах, таниулах, мөрдүүлэх, үр дүнг тооцох, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан аянд хамрагдаж буй байгууллага /боловсрол, уул уурхай, барилгын салбар/ нэр дэвшүүлнэ.

## **9. Сайн засаглалыг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцож буй иргэн, иргэний нийгмийн байгууллага**

*Шагналын зорилго, ач холбогдол:*

- Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, сурталчлах энэ үйл ажиллагаанд иргэдийн татан оруулцуулах, идэвхи чармайлт, санаачилгыг нэмэгдүүлэх

Шалгуур:

- Сайн засаглал, ил тод байдлыг хангах чиглэлээр санал санаачлага гарган хэрэгжүүлсэн, уг үйл ажиллагаа нь төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд ашиглаж болохуйц /судалгаа, шинжилгээ, гарын авлага материал, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт/ үр дүн гарсан, Авлигатай тэмцэх газар, иргэний нийгмийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу

биелэлтэд өөрийн санаачлагаар мониторинг хийн тайлан боловсруулсан, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, нийгмийн хор аюулыг ухуулан таниулах чиглэлээр ном гарын авлага боловсруулан түгээсэн, олон нийтийг хамарсан компани ажил зохион байгуулсан иргэн, иргэний нийгмийн байгуулагыг нэр дэвшүүлнэ.

**Шалгаруулах үйл явц:** Авлигатай тэмцэх газрын даргын 2016 оны А/55 тушаалын хавсралт батлагдсан “Шударга ёсны төлөө” уралдаан зохион байгуулах, үнэлэх аргачлал /ЭНДЭЭС ҮЗЭХ/-ын дагуу, шалгаруулах ажлын хэсэг үнэлнэ.

**Шагнал гардуулах үйл явц:** Шалгаруулах ажлын хэсгээс өгсөн үнэлгээний дүнг Авлигын эсрэг олон улсын өдрийг угтсан арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээлэх ба шагнал гардуулах ажлыг зохион байгуулна.

**Шагналд нэр дэвшүүлэх:**

Оролцогч байгууллага нь удирдамжид заагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу тайлан, холбогдох мэдээлэл /хувь хүний товч намтар, анкет, байгууллагын товч танилцуулга шагналд тухайн нэр дэвшигчийг дэвшүүлсэн үндэслэлээ тайлбарлаж, шагналын шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгаа талаар тодорхойлох ба нотлох баримт/ хавсарган ирүүлнэ.

**Шагналд нэр дэвшүүлэх материалыг хүлээн авах хугацаа:**

“Шударга ёсны төлөө–2016” уралдаанд нэр дэвшүүлж байгаа материалыг 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17.00 цаг хүртэл Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс /№ 303 тоот/-т хүлээн авна.

Холбоо барих утас: 70112467, [delqerbayar@iaac.mn](mailto:delqerbayar@iaac.mn) хаягаар хандана уу.

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**